

## **ЗАВОД НООСНЫ АГУУЛАХАД ТАВИГДАХ ИТГЭМЖЛЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

**(Зумласан ноос угаах үйлдвэрийн агуулах)**

### **НЭГ. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА**

1.1 Агуулахын эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 1.1.1 Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх;
- 1.1.2 Бүрэн ажиллагаатай угаах шугамтай, завод ноос угаах ажиллагаа эрхэлдэг үйлдвэртэй байх;
- 1.1.3 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар байгаль орчны нөлөөллийн үнэлгээ гаргуулсан, завод ноос угаах зөвшөөрөл авсан байх;
- 1.1.4 Агуулахын эзэн (өмчлөгч), эсвэл агуулахыг түрээслэн ажилладаг байх;
- 1.1.5 Хугацаа хэтэрсэн (татвар, банкны болон бусад) өргүй байх;
- 1.1.6 Үйлдвэрийн үндсэн ажилчдын тоо 15-аас доошгүй байх;
- 1.1.7 Завод ноосны чиглэлээр 3-аас доошгүй жил тогтвортой ажиллаж мэргэшсэн барааны мэргэжилтэнтэй байх;

1.2 Агуулах нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 1.2.1 Монгол улсын MNS 5364:2011 стандартын шаардлагыг хангасан;
- 1.2.2 Байрлал нь өөрийн үйлдвэрийн дэргэд бөгөөд 24 цагийн нэгдсэн харуул хамгаалалттай, камержуулсан;
- 1.2.3 Ариутгал, халдваргүйжүүлэлтийг стандартын дагуу тогтмол хийлгэдэг;
- 1.2.4 Агуулахын хашаа нь биржийн барааг саадгүй ачих, буулгах боломжтой, тээврийн хэрэгсэл зогсох, хөдлөх хангалттай талбайтай;
- 1.2.5 Ажилчдад шаардлагатай хөдөлмөр хамгааллын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг тогтмол хэрэглүүлдэг;
- 1.2.6 Биржийн хүлээн зөвшөөрсөн дараах тоног төхөөрөмжүүдээр тоноглогдсон байна. Үүнд:
  - 1.2.7 Биржийн агуулахын бүртгэлийн програмыг ажиллуулах компьютер болон принтер, 1mb-аас доошгүй хурдтай интернэт, 4mb нягтралтай IP камер зэрэг дагалдах тоног төхөөрөмжтэй байх;
    - Стандартчилал хэмжилзүйн газраас баталгаажуулсан гэрчилгээ бүхий баталгаат жин, пүү;
    - Пресслэгч (шахуургын) төхөөрөмж;
    - Шаардлагатай тохиолдолд хөргөлт, халаалтын систем;
    - Шаардлагатай тохиолдолд өргөх, буулгах, ачих төхөөрөмж;
- 1.2.8 Барааны бүртгэл хөтлөх ажилтантай байна.

### **ХОЁР. БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ**

2.1 Итгэмжлэл хүсэгч нь дараах баримт бичгийг Биржид бүрдүүлж өгнө. Үүнд:

- 2.1.1 Итгэмжлэл хүссэн өргөдөл;
- 2.1.2 Агуулахын албан ёсны болон байршил тодорхойлох хаяг, харилцах утас, имэйл хаяг;
- 2.1.3 Үйлдвэрийн хашаан доторх агуулах тус бүрийн чанар, багтаамжийн мэдээлэл;
- 2.1.4 Агуулахын тоног төхөөрөмжийн талаарх бүрэн мэдээлэл;
- 2.1.5 Агуулах тус бүрийн гаднах, доторх зургууд (8x12-оос доошгүй хэмжээтэй, булан, хана, шал, тааз, хаалга, тоног төхөөрөмжийг дэлгэрэнгүй харуулсан);
- 2.1.6 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, түүний хуулбар;
- 2.1.7 Агуулахын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, түүний хуулбар;
- 2.1.8 Хэрэв агуулахыг түрээслэдэг бол түрээсийн гэрээ, түүний хуулбар;
- 2.1.9 Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (шаардлагатай тохиолдолд эрх бүхий аж ахуйн нэгжийн гаргасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хамт), түүний хуулбар;
- 2.1.10 Татварын байгууллагын тодорхойлолт, түүний хуулбар;
- 2.1.11 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт, түүний хуулбар;
- 2.1.12 Энэ шалгуур үзүүлэлтийн 1.1.6-д заасан ажилчдын нийгмийн даатгалын дэвтэр, түүний хуулбар;
- 2.1.13 Агуулахын тоног төхөөрөмжийн гэрчилгээ, түүний хуулбар.
- 2.1.14 Итгэмжлэлийн гэрчилгээний нэг удаагийн хураамж болох 300,000 (гурван зуун мянган) төгрөгийг
  - Хаан банк 5131004545,
  - Төрийн банк 106000999991 эдгээрийн аль нэг дансанд тушаасан баримт

2.2 Бүрдүүлэх баримт бичгийн 2.1.1-2.1.5 заалт дахь баримтыг албан бичгээр үйлдэж, тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажуулсан байна.

2.3 Бүрдүүлэх баримт бичгийн 2.1.6-2.1.13 заалт дахь баримтыг эх хувиар нь авчрах боломжгүй бол нотариатаар тухайн онд баталгаажсан хуулбарыг авчирч болно.

### **ГУРАВ. ИТГЭМЖЛЭЛ СУНГАХАД ШААРДАГДАХ БАРИМТ БИЧИГ**

3.1 Итгэмжлэлийн гэрээний хугацаа дуусахаас ажлын 10 өдрийн өмнө итгэмжлэгдсэн агуулах гэрээ сунгуулах хүсэлтийг Биржид гаргана.

3.2 Итгэмжлэл сунгуулахад бүрдүүлэх баримт бичиг :

- 3.2.1 Итгэмжлэл сунгуулах өргөдөл, албан бичгээр;
- 3.2.2 Энэ шалгуур үзүүлэлтийн 2.1.2-2.1.5 заалтад бүрдүүлсэн баримт бичгүүдээс өөрчлөгдсөн баримт бичиг;
- 3.2.3 Энэ шалгуур үзүүлэлтийн 2.1.6-2.1.13 заалт дахь баримт бичгүүдээс (хугацаа дууссан болон бусад шалтгаанаар) шинэчлэгдсэн баримт бичиг.

3.3 Итгэмжлэл сунгахад шаардагдах баримт бичгийг хүлээн авахдаа энэ шалгуур үзүүлэлтийн 2.2 болон 2.3-т заасан нөхцлийг баримтална.

—oOo—